

САЙН НОЁН ХАН Т.НАМНАНСҮРЭНГИЙН МОНГОЛЫН  
ТӨРИЙН ДИПЛОМАТ АЛБАНД ГҮЙЦЭТГЭСЭН  
ТҮҮХЭН ҮҮРЭГ

Ж.Бор\*

**Т**усгаар тогтнолоо шинэхэн зарласан аливаа улсад гадаад харилцаатайгаа холбогдуулан эн тэрүүнд яаралтай хийж гүйцэтгэх гурван чухал ажил байдаг. *Нэгдүгээрт:* Гадаад хэргийн яамаа шуурхай зохион байгуулах; *Хоёрдугаарт:* Хөрш зэргэлдээ болон дэлхийн бусад улсуудаар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх; *Гуравдугаарт:* Гадаад бодлогынхоо чиг шугамыг боловсруулан гаргах зэрэг болно.

Сайн ноён хан Т.Намнансүрэн агсан нь улсын Ерөнхий сайдын хувьд шинээр тусгаар тогтнолоо зарлаж, үндэснийхээ төр улсыг дөнгөж сэргээгээд байсан Монгол улсын гадаад бодлого, гадаад харилцаатай холбогдолтой энэ гурван чухал ажлын гурвууланд нь гар бие оролцож явсан билээ. Тэрбээр ажил үүргийнхээ дагуу Монголын гадаад хэргийн яамыг удирдлагаар хангах ёстой байсан. Ажлынхаа энэ хүрээнд гадаад хэргийн яамны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, ажил үүргийг нь чанаржуулахыг хичээж байжээ.

Хоёрт, шинээр тулгар тогтсон Монгол улсын тусгаар тогтнолыг хөрш зэргэлдээ улсуудаараа хүлээн зөвшөөрүүлэх, тэр тусмаа дэлхийн нөлөө бүхий орнуудаар хүлээн зөвшөөрүүлэх явдал нь сайн ноён хан Т.Намнансүрэнг Ерөнхий сайд болсны дараа ч Монгол төрийн өмнө зогсож байсан амин чухал асуудал байсаар байсан юмаа. Ийнхүү 1912 онд Нийслэл Хүрээнд болсон Монгол, Оросын хэлэлцээг бэлдэж явуулах Их Хүрээний 1912 оны хэлэлцээрийг дипломатын талаар бэлдэж гарын үсэг зуруулан батлуулах, мөн онд Орост хийсэн төрийн дээд айлчлалд оролцсон явдал нь түүнийг дипломат ажлыг зохион байгуулагчийн хувьд, төрийг

\* МУИС-ийн ОУХС-ийн профессор, доктор (Ph.D)

төлөөлж гадаад харилцаанд оролцдог дипломатчийн хувьд бүрэлдэн тогтоход зохих ёсоор нөлөөлсөн юм.

Нөгөө талаар дипломатын нарийн нандин, асар их ээдрээтэй, бас хүнд хүчир ажилд орж очиход сайн ноён хан Т.Намнансүрэнгийн олж авсан гэрийн сургалтын өндөр боловсрол, төрөлх зан чанарт нь байсан соёлтой харилцаа чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Зарим утгаар жинхэнэ дипломатч хүн төрөлхөөс заяагдсан байдаг гэж үздэг. Өөрөөр хэлбэл дипломат нарийн нандин чанар нь хүний төрөлхийн зан төрхөд заяадаг гэж үздэг төдийгүй их үйл явдлыг бариа зөрөөн дээр ухаарах, улс төрийн хэтийн үр дагаврыг урьдчилан мэдрэх мэдрэмжийг байгалиас заяагдмал байдаг гэж үздэг. Жинхэнэ дипломатч хүн болоход зайлшгүй шаардлагатай энэ нэг чадвар, энэ нэг мэдрэмж Намнансүрэн агсны төрөлх зан чанарт хангалттай байсныг бид олон жишээгээр нотолж болно. Жишээлбэл тэрбээр Монголын гадаад бодлогыг хөршүүдийнхээ хувьд маш уян хатан байх ёстой гэж үзэж байсан бөгөөд энэ байр суурийнхаа хүчинд чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд зэрэг том дипломатчуудаас илүү уян хатан дипломатч болж чадсан юм.

Тухайлбал Их Хүрээний 1912 оны дипломат хэлэлцээ явагдаж байх үеэр оросын төлөөлөгч Коростовец Монголын засгийн газар Японтой хэлэлцээ хийх санаатай байгаа мэдээ олж сонсоод Сайн ноён ханаас лавлан асуухад “Хүрээний засаг захиргаа, шашин шүтлэг нэгтэйн хувьд Японтой шууд харилцаа тогтооход дөхөмтэй хэмээн үзэж, Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх зорилготой тусгай элчийг томилон одуулахаар төлөвлөн байгаа” гэж хариулсан байдаг.

Гэтэл дараа нь мөн асуудлыг лавлахаар уулзсан да лам Цэрэнчимэд “Ар Монгол нь Өвөр Монголыг Хятадад идэгдэхээс хамгаалахыг завдан буй бөгөөд Өвөр Монголын хувь заяанд үүрэг холбогдолтой Японтой гэрээ байгуулж, зорьсондоо хүрч болно. Хэрвээ Япон улс Ар Монголын өөртөө эзэрхэх ёс болон Өвөр Монголын талаарх Ар Монголын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх аваас Өвөр Монголын ноёдыг ятган сэнхрүүлж Японы өмгөөлөлд оруулж чадна” гэсэн байдаг.

Энэ хоёр хариултаас Намнансүрэн агсны хариулт “шашин нэгтэй” гэсэн учир шалтгааныг үндэслэн гаргаж ирснээрээ үнэмшихэд энгүүн, мөн бусад асуудлыг бүрхэгдүүлэн орхисноороо илүү уян хатан болсон байдаг.

Энэ нь нөгөө талаар Сайн ноён хан дипломатын ажиллагаа, дипломат хэлэлцээг “тоглоомын талбай” гэдгийг бусдаас түрүүн ойлгож, тэр тоглоомд “гарын том модтой” оролцож байх ёстой гэж үзэж байлаа. Тухайлбал Орост төрийн дээд айлчлал хийж байх үедээ тэр “гарын том модоо” Японы асуудал гэж үзэж байсан. Тиймээс Петербургийн хэлэлцээ явагдаж байх үеэр Их Хүрээнд “Японы тухай хэргийг хэрхэвч задруулж болохгүй” гэсэн цахилгаан явуулж байжээ.

Энэ нь хэрэгтэй үе хүртлээ “гарын модныхоо” нууцыг хадгалах гэсэн дипломатын арга ажиллагаатай холбоотой бодол байсан юм. Тиймээс ч Монголын гадаад бодлогын үндсэн чиг шугамын нэг болсон Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх үүрэг, хоёрдахь чиг шугам болсон Өвөр Монголыг нэгтгэх асуудал бүтэмжгүй болох нь тодорхой болсон 1913 оны 12 дүгээр сарын 23-нд Сайн ноён хан “гарынхаа мод”-ыг гэнэт ил гаргаж Японд холбогдолтой нэгэн чухал захидлыг оросын ГЯЯ-ны Сайд Сазоновт илгээсэн. Энэ нь Богд хаан Жавзандамба гэгээнээс Японы Эзэн хаанд хүргүүлэхээр төрийн тамгаа дарсан “Өвөр Монголоос цэргээ татаж авах талаар хятадын Засгийн газарт хүчлэн ухуулж, Ар, Өвөр Монгол овогтныг нэгтгэх үйл хэрэгт дэмжлэг үзүүлэхийг хүссэн төдийгүй Их Хүрээнд Япон улсын бүрэн эрх барих сайдыг томилон суулгахыг хүссэн” захидал бичиг байсан билээ.

Энэ нь тухайн үед Монголыг тойрон бүрэлдсэн гадаад орчны таагүй байдлаас болж үр дүнд хүрээгүй болохоос бус дипломатын хувьд маш зөв арга барил байсан юм.

Харин Хиагтад хийхээр төлөвлөж байсан гурван этгээдийн хэлэлцээг Японыг оролцуулаад дөрвөн этгээдийн хэлэлцээ болгох гэж оролдож байсан нь алсын хараатай, хэтийн их мэдрэмжтэй дипломатч байсныг нь харуулсан юм. Энэ нь хэлэлцээ явагдах үед Орос, Хятадын талаас ирж болох дарамт шахалтыг урьдчилан харж, тэр шахалтыг Японы хүчин зүйлээр зөөллөх гэсэн нарийн бодлого байсан. Хоёр талын дарамт шахалтыг зөөллөх энэхүү бодлого нь сайн ноён ханы гадаад бодлогын үзэл баримтлалтай холбоотой байсныг хэлэх хэрэгтэй.

Аливаа улс орон туурга тусгаар болсны дараагаар гадаад харилцаа, гадаад бодлогын номлол сургааль гарч ирж хөгждөг нь хууль билээ.

Тэр ч ёсоор ХХ зууны эхээр Монголд гурван янзын үзэл баримтлалтай гадаад бодлогын номлол сургаалиуд гарч ирсэн.

**Нэгд, Хаант Оросыг түших үзэл баримтлал,**

**Хоёрт**, Японыг түших үзэл баримтлал,

**Гуравт**, Олон улсыг түших үзэл баримтлал зэрэг болно.

Эдгээрийн нэг, хоёр дахь номлол өөр өөр улсыг боловч нэгэн улсыг гадаад бодлогодоо түшье гэдэг үзэл баримтлалаараа үндсэндээ ижил байсан юм. Гурав дахь номлол нь илүү өргөн далайцтай, илүү ирээдүйтэй байсан боловч хоёр дахь номлолтойгоо Монголын геополитикийн таагүй орчныг эвдэж, хоёр их хөршийнхөө гадаад бодлогын даралтыг зөөллөхөд чиглэсэн үндсэн үзэл баримтлалаараа төстэй байсан юм.

Энэхүү өргөн далайцтай, хамгийн ирээдүйтэй, гуравдахь номлолыг үндэслэгчид нь тухайн үедээ Монголын засгийн газрын толгойд зогсож байсан эрдэнэ жонон ван Ц.Ширнэндамдин, сайн ноён хан Т.Намнансүрэн нар байсан билээ.

Сайн ноён хан Т.Намнансүрэн улсын Ерөнхий сайдын хувиар баримталж, Гадаад хэргийн яамаар дамжуулан хэрэгжүүлж байсан гадаад бодлогын гол чиг шугам нь:

**Нэгд**, Монгол улсын гадаад бодлого нь хөрш улсуудынхаа талаар баримтлах уян хатан зарчим;

**Хоёрт**, олон улсыг түшсэн өргөн харилцааны зарчим;

**Гуравт**, Өвөр Монголоо өмгөөлөх гэсэн үндсэн гурван зарчим дээр тулгуурлаж байсан нь түүний бодлого, дипломатын үйл ажиллагаанаас тод ажиглагддаг.

Энэ бүхний эцэст хэлэхэд сайн ноён хан, улсын Ерөнхий сайд Т.Намнансүрэн нь Монголын гадаад бодлого, гадаад харилцааны онол, дадлагын салбарт гадаад бодлогын чиг шугам, гадаад бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл болсон дипломат арга ажиллагаа боловсрон гарч ирэх, тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх дипломатын тэмцэл, Монголын дипломат алба чанаржихад түүхэнд тэмдэглэгдэх үүрэг гүйцэтгэсэн гавъяат зүтгэлтэн мөнөөс мөн гэдгийг тэмдэглэхийг хүсэж байна.

Article's emphasis is on personal contribution and activities of the first Prime Minister of Mongolia. H.E. Mr. Namnansuren towards strengthening functions of the Ministry of Foreign Affairs. It reveals also his diplomatic abilities, characteristics and his born talents.